



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2026 I

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ





**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС**

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 1 дүгээр сар

**Улаанбаатар хот
2026 он**

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2022-2026 он	6
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	6
I.	Нийгмийн даатгал, халамж	7
II.	Эрүүл мэнд	13
III.	Гэмт хэрэг	16
IV.	Төсөв	25
V.	Хэрэглээний үнэ	28
VI.	Аж үйлдвэр	33
VII.	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	38

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин их
- 1/X** дахин бага
- 0.0 маш бага тоо
- | харьцуулагдахгүй
- 0.0⁺ тэнцүү/ өөрчлөлтгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.


IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрум	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 I	2023 I	2024 I	2025 I	2026 I	
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	261↓21.4	354↑35.6	264↓25.4	300↑13.6	233↓22.3	
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	15 590↑88.1 ¹	202↓98.7	169↓16.3	214↑26.6	189↑11.7	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	351↓3.0	388↑10.5	599↓54.4	630↑5.2	697↑10.6	
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	2.3↑1.6	1.1↓53.2	0.7↓36.4	1.3↑85.7	0.9↓30.8	
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	2 849 ^{0.0}	3 467↑21.7	3 407↓1.7	3 432↑0.7	3 561↑3.8
	Юань (БНХАУ)	Төгрөг	448↑1.6	510↑13.8	475↓6.9	470↓1.1	511↑8.7
	Рубль (ОХУ)	Төгрөг	37↓2.6	50↑35.1	38↓24.0	34↓10.5	46↑35.3
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	2.2↓73.8	7.9↑3.6 ¹	13.2↑67.1	15.8↑19.7	14.3↓9.5	
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	2.1↓62.5	6.6↑3.1 ¹	13.1↑98.5	21.2↑61.8	13.1↓38.2	
Агаарын дундаж температур	°C	-20.9	-17.4	-21.0	-19.1	-4.1	

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I						2026 I			
		Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	Баянгол	8 797	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59
			Чингэлтэй	1 490	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47
			Сүхбаатар	688	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	18	Чингэлтэй	25	Налайх	-	15	Багахангай	21	Хан-Уул	6
			Сонгинохайрхан	20	Багануур	-		Баянзүрх	19	Багануур	0
			Сүхбаатар	18	Багахангай	-		Сүхбаатар	15	Багахангай	0
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	11	Баянзүрх	13	Багануур	6	12	Баянзүрх	11	Сонгинохайрхан	7
			Сүхбаатар	10	Налайх	3		Багануур	9	налайх	4
			Чингэлтэй	9	Багахангай	2		Чингэлтэй	8	Багахангай	0
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	47	Баянгол	104	Багахангай	82	134	Хан-Уул	548	Чингэлтэй	54
			Сүхбаатар	102	Налайх	75		Баянзүрх	323	Багахангай	28
			Чингэлтэй	102	Багануур	29		Сүхбаатар	286	Налайх	26
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	38	Сүхбаатар	61	Сонгинохайрхан	26	38	Сүхбаатар	63	Сонгинохайрхан	25
			Чингэлтэй	52	Багахангай	10		Чингэлтэй	56	Налайх	17
			Баянзүрх	40	Багануур	10		Хан-Уул	41	Баганхангай	13



НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын орлого өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар, нийгмийн даатгалын зарлага 25.3 хувиар тус тус өссөн байна.

2026 оны 1 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн санд нийт 38.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 (10.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 1дүгээр сард

Үзүүлэлт	2025 I	2026 I	<u>2026 I</u> <u>2025 I</u>
	сая төгрөг		хувь
Нийт орлого	34 302.2	38 040.0	10.9
Тэтгэврийн даатгалын сангийн	28 219.2	31 421.2	11.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	2 976.3	3 305.2	11.1
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	2 067.0	2 219.4	7.4
Ажилгүйдлийн даатгалын сангийн	1 039.7	1 094.2	5.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн	-	-	-
Нийт зарлага	38 652.6	48 438.4	25.3
Тэтгэврийн даатгалын сангийн	34 310.1	39 161.9	14.1
Тэтгэмжийн даатгалын сангийн	2 225.6	3 371.8	51.5
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	201.6	222.2	10.2
Ажилгүйдлийн даатгалын сангийн	1 915.3	5 682.5	3.0**

¹-Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ЗУРАГ 1.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2026 оны 1 дүгээр сард



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 82.6 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 5.8 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 8.7 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 2.9 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

ЗУРАГ 2.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2026 оны 1 дүгээр сард



Нийгмийн даатгалын сангаас 2026 оны 1 дүгээр сарын байдлаар даатгуулагч иргэдэд 48.4 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8 (25.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын 80.8 хувийг тэтгэврийн, 0.5 хувийг ҮОМШӨ-ний, 7.0 хувийг тэтгэмжийн, 11.7 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сард


Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчид			Олгосон тэтгэвэр, тэтгэмж		
	2025 I	2026 I	2026 I 2025 I	2025 I	2026 I	2026 I 2025 I
	тоо		хувь	сая төгрөг		хувь
Сангийн нийт зарлага	37 706	38 234	1.4	38 652.7	48 438.4	25.3
Тэтгэврийн даатгалын сан	35 029	35 873	2.4	34 310.2	39 161.9	14.1
Өндөр насны	27 959	28 866	3.2	28 298.4	32 026.6	13.2
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр	3 982	3 835	-3.7	2 369.2	2 839.0	19.8
Тэжээгчээ алдсаны	1 185	1 211	2.2	726.9	921.6	26.8
Цэргийн тэтгэвэр	1 903	1 961	3.0	2 913.8	3 372.6	15.7
Бусад зардал	-	-	-	1.9	2.1	10.5
Тэтгэмжийн даатгалын сан	1 553	1 055	-32.1	2 225.6	3 371.8	51.5
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	1 102	664	-39.7	474.8	465.0	-2.1
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	386	304	-21.2	1 624.8	2 645.7	62.8
Оршуулгын тэтгэмж	65	87	33.8	126.0	261.0	2.1**
Бусад зардал	-	-	-	-	0.0	-
ҮОМШӨ¹-ний даатгалын сан	183	175	-4.4	201.6	222.2	10.2
Тахир дутуугийн тэтгэмж	148	139	-6.1	157.6	155.8	-1.1
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	28	25	-10.7	28.3	31.5	11.3
Тэтгэмж, төлбөр	7	11	57.1	15.5	34.8	2.2**
ҮОМШӨ ¹ -ний сувилал	-	-	-	0.2	-	-
Бусад зардал	-	-	-	-	0.0	-
Ажилгүйдлийн даатгалын сан	941	1 131	20.2	1 915.3	5 682.5	3.0**
Ажилгүйдлийн тэтгэмж	941	1 131	20.2	1 915.3	5 682.5	3.0**

2026 оны 1 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 38234 хүнд 48438.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 35873 хүнд 39161.9 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 1055 хүнд 3371.8 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 1131

хүнд 5682.5 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 175 хүнд 222.2 сая төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, ЖИЛ БҮРИЙН 1 ДҮГЭЭР САРД



2026 оны 1 дүгээр сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 35873 хүнд 39.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоны 81.8 хувийг өндөр настны, 7.2 хувийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 2.4 хувийг тэжээгчээ алдсаны, 8.6

хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна. Тэтгэвэр авагчдийн 81.8 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 907 (3.2%) хүн, 4.9 (14.1%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн зарлага өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өссөн байна.

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн арга хэрэгсэл юм. Нийгмийн халамжийн сангаас 2026 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 115.0 мянган хүнд 13685.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдож, өнгөрсөн оны мөн үеэс 1480 (1.3%) хүн, 743.3 (5.7%) сая төгрөгөөр өссөн байна. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 9590.2 (70.8%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 1347.9 (10.0%) сая төгрөгийг нийгмийн халамжийн

тэтгэвэрт, 1522.9 (11.2%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 383.2 (2.8%) сая төгрөгийг эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж, үлдсэн 841.7 (5.2%) сая төгрөгийг онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, ахмад настны тэтгэмж хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж болон бусад тусламж тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2025 I		2026 I		2026 I 2025 I
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	
	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	хувь
Нийт олгогдсон тэтгэвэр, тэтгэмж	113 590	12 942.6	115 070	13 685.8	5.7
Тэтгэвэр	2 626	1 077.3	3 019	1 347.9	25.1
Асаргааны тэтгэмж	4 054	1 256.1	4 620	1 522.9	21.2
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	8 528	419.0	8 049	383.2	-8.5
Алдарт эхийн одонгийн тусламж	-	-	-	-	-
Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж	11	3.0	13	2.3	-23.3
Хүүхдийн мөнгө	95 953	9 585.4	95 902	9 590.2	0.1
Насны хишиг	-	-	-	-	-
Онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	195	402.9	1 392	549.0	36.3
Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт	308	64.3	410	96.4	49.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	436	30.9	420	45.6	47.6
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	-	-	-	-	-
Бусад	1 479	103.7	1 245	148.3	43.0

Энэ оны 1 дүгээр сарын байдлаар 410 ахмадад 96.4 сая төгрөгийн ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт зарцуулагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 102 (33.1%) хүн, 32.1 (50.0%) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 1 ДҮГЭЭР САРД

Үзүүлэлт	2025 I		2026 I		2026 I 2025 I
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	
Бүгд	308	64 306.1	410	96 432.0	50.0
Оршуулгын тэтгэмж	1	2 000.0	1	2 000.0	0.0 ^е
Амралт, сувилал	112	30 525.0	3	805.0	-97.4
Рашаан, сувилал	69	13 774.1	168	43 273.0	3.1**
Протез	113	14 395.0	178	22 470.0	56.1
Ортопед, тусгай хэрэгсэл	11	3 332.0	47	26 484.0	7.9**
Ахмадын хүндэтгэл	-	-	-	-	-
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	2	280.0	13	1 400.0	5.0**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал хүний тоо 16 (3.7%) буурсан бол олгосон тэтгэмж 14.7 (47.7%) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 1 ДҮГЭЭР САРД

Үзүүлэлт	2025 I		2026 I		2026 I 2025 I
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	
Бүгд	436	30 855.4	420	45 579.2	47.7
Харилцаа, холбооны зардлын хөнгөлөлт	334	6 607.1	300	5 977.4	-9.5
Оршуулгын тэтгэмж	4	8 000.0	2	6 000.0	-25.0
Цэцэрлэг сургуулийн унааны зардал	24	4 800.0	15	3 000.0	-37.5
Рашаан сувилал	6	1 513.3	12	4 427.8	1.9**
Протез	8	1 650.0	19	2 790.0	69.1
Ортопед тусгай хэрэгсэл	1	25.0	43	19 324.0	77.2**
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	59	8 260.0	29	4 060.0	-50.8
Бусад	-	-	-	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт, тусламж авсан нийт хүний дийлэнх буюу 71.4 хувийг харилцааны холбооны зардлын хөнгөлөлт авсан иргэд эзэлж байгаа боловч

олгосон тэтгэмж нь 13.1 хувь байна. Харин ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, тусламж авсан иргэдийн мөнгөн дүн 42.4 буюу хамгийн их хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Байнгын асаргаа шаардлагатай иргэн: Бусдын тусалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

Бүтэн өнчин хүүхэд: Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

Өрх толгойлсон эх /эцэг/: Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ: Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ: Иргэн, аж ахуйн нэгж, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг тусалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн сарын мэдээ



ЭРҮҮЛ МЭНД

2026 оны 1 сард 230 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 70 (23.3%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 2026 оны 1 сард 230 эх амаржиж, 233 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 70 (23.3%), мэндэлсэн хүүхэд өмнөх оны мөн үеэс 67 (22.3%) хүүхдээр

тус тус буурсан байна. Амьгүй төрөлтийн 1 тохиолдол бүртгэгджээ. Нийт амаржсан эхчүүдийн дунд гэртээ төрсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.


ХҮСНЭГТ 8. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2024 I	2025 I	2026 I	Өөрчлөлт %
Амаржсан эхийн тоо	260	300	230	-23.3
Гэрийн төрөлт	-	-	-	-
Хяналтгүй төрөлт	-	2	2	0.0 ⁼
Амьгүй төрөлт	1	1	1	0.0 ⁼
Амьд төрсөн хүүхэд	264	300	233	-22.3
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	1	3	3	0.0 ⁼
1-5 настай хүүхдийн эндэгдэл	1	-	-	-
Нас барсан хүн	92	68	96	29.2

2026 оны 1 сард 0-1 хүртэл насандаа эндсэн 3 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй үзүүлэлттэй байгаа бол 1-5 настай хүүхдийн эндэгдэл бүргэгдээгүй эерэг

үзүүлэлттэй байна. Дүүргийн хэмжээнд нас баралт 96 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 28 (29.2%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



Эрүүл мэнд

Дүүрэгт 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 189 халдварт өвчин бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 25 (11.7%) тохиолдлоор буурсан байна. Цочмог халдварт өвчний 42.5 хувийг салхин

цэцэг, 3.9 хувийг улаан эсэргэнэ, 4.7 хувийг энтервируст цэврүүт фарингит, 8.7 хувийг улаан бурхан, 40.2 хувийг цусан суулга, ёлом, хепатит, сальмонеллэз зэрэг өвчин тус тус эзлээд байна.

ХҮСНЭГТ 9. ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн 1 дүгээр сард

Төрөл	Хэмжих нэгж	2024 I	2025 I	2026 I	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	тоо	168	214	189	-25	-11.7
	10000 хүнд	76.3	12.3	7.3	-5	
Вируст хепатит	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	0.7	-	-	-	
Цусан суулга	тоо	4	12	6	-6	-50.0
	10000 хүнд	0.2	0.5	0.2	-3	
Сальмонеллэз	тоо	1	1	2	1	1.0**
	10000 хүнд	-	-	0.1	0.1	
Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга өвчин	тоо	-	1	-	-1	1.0**
	10000 хүнд	-	-	-	-	
Хоолны хордлого	тоо	-	-	5	5	5.0**
	10000 хүнд	-	-	0.2	0.2	
Энтервируст халдвар тодорхойгүй/В34.1/	тоо	-	-	6	6	6.0**
	10000 хүнд	-	-	0.2	0.2	
Салхинцэцэг	тоо	72	114	54	-60	-52.6
	10000 хүнд	3.1	4.6	2.1	-2.5	
Гахай хавдар	тоо	6	-	2	2	2.0**
	10000 хүнд	0.3	-	0.1	0.1	
Улаан эсэргэнэ	тоо	13	7	5	-2	-28.6
	10000 хүнд	0.6	0.28	0.2	0.08	
Ёлом	тоо	-	2	2	-	-
	10000 хүнд	-	0.1	0.1	-	
Бруцеллэз	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Менингококкт халдвар	тоо	-	-	1	1	1.0**
	10000 хүнд	-	-	-	-	
Энтервируст тууралттай цэврүүт фарингит	тоо	11	4	4	-	-
	10000 хүнд	0.5	0.2	0.2	-	
Эритема	тоо	-	-	5	5	5.0**
	10000 хүнд	-	-	0.2	0.2	
Улаан бурхан	тоо	-	-	11	11	11.0**
	10000 хүнд	-	-	0.4	0.4	
Хачигт рикеттсиоз	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Бусад халдварт өвчин	тоо	-	-	24	24	24.0**
	10000 хүнд	-	-	0.9	0.9	
Тэмбүү	тоо	35	30	35	5	16.7
	10000 хүнд	1.4	1.2	1.4	0.2	
Гонококкт халдвар	тоо	6	17	6	-11	-64.7
	10000 хүнд	0.2	0.7	0.2	-0.5	
Трихомониаз	тоо	10	6	10	4	66.7
	10000 хүнд	0.4	0.2	0.4	0.2	

Төрөл	Хэмжих нэгж	2024 I	2025 I	2026 I	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Сүрьеэ	тоо	10	20	10	-10	-50.0
	10000 хүнд	0.4	0.8	0.4	-0.4	
ДОХ	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	-
Мөөгөнцөр	тоо	-	-	1	1	-
	10000 хүнд	-	-	-	-	-

Өнгөрсөн оны мөн үеэс гонозокт халдвар 11 (64.7%) тохиолдлоор буурсан эерэг үзүүлэлттэй байна. 10.0 мянган хүн тутмын 1.4 нь тэмбүү, 0.4 заг хүйтэн буюу трихомониаз өвчнөөр өвчилж байна.

Баянгол дүүрэгт 2026 оны 1 сард 127 хүн цочмог халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 25 (11.7%) хүнээр буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Эх үүсвэр:
Дүүргийн Эрүүл мэндийн төвийн сарын мэдээ



ГЭМТ ХЭРЭГ

Баянгол дүүрэгт 697 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 67 (10.6%) хэргээр өссөн байна.

2026 оны 1 сард 697 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 67 (10.6%) хэргээр өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 33.0 хувьтай байгаа нь 22.8 нэгж хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 631 иргэн хохирч, 9.5 сая төгрөгийн хохирол учруулснаас 1.2 сая (12.1%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 42.5 хувийг залилан, 15.1 хувийг хүний эрүүл мэндийн

халдашгүй байдлын эсрэг, 13.6 хувийг хулгайн, 0.0 хувийг танхайрах, 3.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 2.6 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг, 4.3 хувийг дээрмийн, 1.9 хувийг хүчин, 0.7 хувийг хүнийг санаатай алах, 16.4 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.


ХҮСНЭГТ 10. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн 1 дүгээр сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 I	2025 I	2026 I	Тоо	Хувь
Нийт гэмт хэрэг	599	630	697	67	10.6
Хүнийг санаатай алах	3	1	5	4	4.0*
Хүний амьд явах эрхийн эсрэг	9	18	18	-	0.0 ^o
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	101	103	105	2	1.9
Хүчиндэх	7	9	13	4	44.4
Хулгайлах	128	170	95	-75	-44.1
Дээрэмдэх	15	29	30	1	3.4
Залилан	232	198	296	98	49.5
Танхайрах	-	1	-	-1	-
ХАБТХАЖЭ	9	15	21	6	40.0
Бусад гэмт хэрэг	95	87	114	27	31.0

Өнгөрсөн оны мөн үеэс дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг өссөн сөрөг үзүүлэлтэд хүнийг санаатай алах 4 (4 дахин), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 2 (1.9%), хүчиндэх 4 (44.4%), дээрэмдэх 1 (3.4%), залилан 98 (49.5%), хөдөлгөөний аюулгүй байдал,

тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 6 (40.0%) нэгжээр, бусад гэмт хэрэг 27 (31.0%) нэгжээр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин хулгайлах 75 (44.1%) танхайрах 1 (100.0%), хэргээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 5.

БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2026 оны 1 дүгээр сард

Бүртгэгдсэн хулгайн гэмт хэргийн 76 (80.0%) нь иргэдийн өмчийн, 16 (16.8%) нь халаасны, 2 (2.1%) нь авто тээврийн хэрэгсэл, 1 (1.1%) нь бусад хулгайн гэмт хэрэг тус тус эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс халаасны хулгай хамгийн их буюу 82.2 хувь буурсан байна.

Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилдаг болсон. 2026 оны 1 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 4352 (93.4%) нь хөнгөн хэрэг, 305 (6.6%) нь хүнд хэрэг байна.

ХҮСНЭГТ 11.


БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, хэлтсээр, 2026 оны 1 дүгээр сард

Төрөл		Бүгд		
		Тоо	Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс
Нийт гэмт хэрэг			697	383
Хэргийн ангилал	Хөнгөн	623	341	282
	Хүнд	74	42	32
Гэмт хэргийн төрөл	Хүнийг алах	5	4	1
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	18	13	5
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	105	54	51
	Хүчиндэх	13	8	5
	Хулгайлах	95	48	47
	○ Иргэдийн өмчийн	76	39	37
	○ Авто тээврийн хэрэгслийн	2	1	1
	○ Халаасны	16	7	9
	○ Бусад	1	1	0
	Дээрэмдэх	30	16	14
	Залилах	296	169	127
	Танхайрах	0	0	0
	ХАБТХАЖЭ ²	21	11	10
	Бусад	114	60	54

Нийт бүртгэгдсэн 697 гэмт хэргээс 383 (55.0%) нь цагдаагийн I хэлтэст, 314 (45.0%) нь цагдаагийн II хэлтэст гарч, өнгөрсөн оны мөн үеэс I хэлтэст 62 (19.3%) хэргээр, II хэлтэст 5 (1.6%) хэргээр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 35 (5.0%) нь согтуугаар, 25 (3.6%) нь бүлэглэн, 104 (14.9%) нь эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг байна.


ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн цаг, гарагаар, жил бүрийн 1 дүгээр сард



Энэ оны 1 дүгээр сарын байдлаар даваа, мягмар, лхагва гаригт хамгийн их буюу 311 (44.6%) гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн хамгийн их үйлдэгдсэн нь мягмар гарагийн 06:00-14:00 цагийн хооронд байна.

Дүүргийн хэмжээнд 2026 оны 1 дүгээр сарын байдлаар гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн газар болох гэр, орон сууцанд 230 (36.1%) хэрэг, гудамж талбайд 173 (24.8%) хэрэг, олон нийтийн газарт 160 (23.0%) хэрэг, бусад үйлдэгдсэн газар 134 (16.1%) тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, жил бүрийн 1 дүгээр сард



Гэмт хэргийн гаралтыг хороо тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20-р хороо 28 (45.2) хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол бусад хороодод 5.9 хувиас 1.9 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Дүүргийн гуравдугаар хорооны нутаг дэвсгэрт 52 (7.5%) гэмт хэргийн бүртгэгдсэн нь хамгийн их байсан бол хамгийн бага нь 27, 30, 31,34 дүгээр хороодод бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 12. НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, хороо, төрлөөр, 2026 оны 1 дүгээр сард

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ ²	Бусад
Тоо											
Бүгд	697	5	18	105	13	95	30	296	0	21	114
I хороо	50	-	2	2	-	6	3	19	-	1	17
II хороо	52	-	1	2	-	11	1	30	-	-	7
III хороо	29	-	2	2	-	2		17	-	1	5
IV хороо	31	1	1	3	-	6		3	-	2	15
V хороо	24	-	-	4	1	5	1	10	-	1	2
VI хороо	33	-	1	3	-	5	1	14	-	2	7
VII хороо	15	-	-	2	-	2	1	5	-	1	4
VIII хороо	16	-	-	8	-	2	-	5	-	-	1
IX хороо	20	-	-	4	2	2	-	7	-	1	4
X хороо	14	-	1	2	1	3	1	4	-	-	2
XI хороо	23	-	1	6	-	2	-	7	-	2	5
XII хороо	16	-	1	2	2	3		6	-	-	2
XIII хороо	41	-	-	6	-	5	2	24	-	1	3
XIV хороо	25	-	-	7	1	3	2	8	-	-	4
XV хороо	15	-	-	1	1	2	1	8	-	-	2
XVI хороо	19	1	-	6	-	4	1	5	-	-	2
XVII хороо	22	1	-	5	2	1	1	8	-	1	3
XVIII хороо	29	-	1	2	-	3		16	-	2	5
XIX хороо	19	1	-	3	-	5	1	8	-		1
XX хороо	34	-	-	8	-	4	1	15	-	1	5
XXI хороо	10	-	-	1	-	-	-	7	-	-	2
XXII хороо	13	-	1	3	-	2	3	3	-	-	1
XXIII хороо	9	-	2	3	1			2	-	1	-
XXIV хороо	18	-	1	4		1	1	9	-	-	2
XXV хороо	13	-	-	4	1	2	-	5	-	-	1
XXVI хороо	26	1	1	2	-	3	-	16	-	1	2
XXVII хороо	5	-	1	2	-	-	-	2	-	-	-
XXVIII хороо	14	-	-	1	-	4	2	7	-	-	-

Гэмт хэрэг

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ ²	Бусад
	Тоо										
XXIX хороо	27	-	-	2	-	4	3	13	-	-	5
XXX хороо	1	-	-	-	-	-	-	1	-	-	-
XXXI хороо	7	-	1	-	-	1	2	3	-	-	-
XXXII хороо	9	-	-	1	-	2	-	2	-	1	3
XXXIII хороо	11	-	-	1	-	-	1	7	-	1	1
XXXIV хороо	7	-	-	3	1	-	1	-	-	1	1


Бүртгэгдсэн зөрчил:

Дүүргийн нутаг дэвсгэрт энэ оны 1 дүгээр сарын байдлаар 3264 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 544 (14.3%) хэргээр буурч, зөрчил гаргасан 3240 иргэн, хуулийн

этгээдийг 140.8 сая төгрөгөөр торгосон бол 24 хүнийг “Зөрчлийн тухай” хуулиар баривчилжээ.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 41.1 хувь нь I хэлтэст, 58.9 хувь нь II хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 8. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, хэлтсээр, жил бүрийн 1 дүгээр сард




Нийт илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт, илрүүлэлтийн хувийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад I хэлтэс 39 (2.3%) хэргээр, II хэлтэс 381 (18.4%) хэргээр буурсан байна. Нийт илрүүлсэн зөрчлийг нийслэлийн 9 дүүргийн хэлтсүүдтэй харьцуулахад Баянгол дүүргийн цагдаагийн II хэлтэс тавдугаарт, I хэлтэс арван наймдугаарт эрэмбэлэгдэж байна.

2026 оны 1 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн нийт зөрчлийн 4445 (13.3%) нь даваа, 5124 (15.3%) нь мягмар, 5027 (15.0%) нь лхагва, 5384 (16.1%) нь пүрэв, 5253 (15.7%) нь баасан, 4066 (12.1%) нь бямба, 4232 (12.5%) нь ням гарагуудад тус тус үйлдэгдсэн байна.

ХҮСНЭГТ 13. НИЙТ БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, үйлдэгдсэн гарагаар, 2026 оны 1 дүгээр сард

Үзүүлэлт	Бүгд	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
	Тоо							
Нийт	3 264	361	459	362	570	623	485	404
I хэлтэс	1 694	212	194	213	297	282	271	225
II хэлтэс	1 570	149	265	149	273	341	214	179

I хэлтэст бүртгэгдсэн нийт зөрчлийн 297 (9.1%) хэрэг нь пүрэв гарагт, II хэлтэст бүртгэгдсэн зөрчлийн 341 (21.7%) хэрэг нь баасан гарагт гарсан нь хамгийн их хувийг эзэлж байна.

ЗУРАГ 9. НИЙТ БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, үйлдэгдсэн цагаар, 2026 оны 1 дүгээр сард

Харин үйлдэгдсэн цагаар харвал 13.00-18.00 цагийн хооронд 934 (28.6%) хэрэг зөрчил бүртгэгдсэн нь хамгийн их байгаа бөгөөд 06.00-12.00 цагийн хооронд 834 (25.6%), 19.00-24.00 цагийн хооронд 758 (23.2%), 01.00-05.00 цагийн хооронд 738 (22.6%) зөрчил тус тус бүртгэгдээд байна.

Зөрчлийн улмаас хохирсон:

340 иргэний 221 (65.0%) нь эмэгтэй, 38 (11.2%) 7-17 насны, 70 (20.6%) нь 18-29 насны, 99 (29.1%) нь 30-39 насны, 73 (21.5%) нь 40-49 насны, 41 (12.1%) нь 50-59 насны, 10 (3.0%) нь

60-69 насны, 9 (2.5%) нь 70-аас дээш насны ахмадууд байна. Хохирсон иргэдийн дийлэнх буюу 167 (49.1%) иргэн нь ажилгүй иргэд байна.

Зөрчил гаргасан:

437 иргэний 160 (36.6%) нь эмэгтэй, насаар нь авч үзэхэд 30-44 орчим насны 238 иргэд илүү зөрчил гаргаж байна.

ЗУРАГ 10. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, боловсролын түвшин, 2026 оны 1 дүгээр сард



Зөрчил гаргасан иргэдийн 145 (33.2%) нь дээд, 10 (2.3%) нь тусгай мэргэжлийн, 274 (62.7%) нь бүрэн дунд, 6 (1.4%) нь суурь, 1 (0.2%) нь бага, 1 (0.2%) нь боловсролгүй хүмүүс эзэлж байна.

Нийт зөрчил гаргагчдыг нийгмийн байдлаас нь үзвэл төрийн албан хаагч 9 (2.1%), хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 36 (8.2%), төрийн бус байгууллагын ажилтан 6 (1.4%), хувиараа хөдөлмөр эрхлэгч 96 (22.0%), оюутан 1 (0.2%), ажилчин, малчин 4 (0.9%), сурагч 1 (0.2%), ажилгүй 265 (60.6%), бусад 19 (4.4%) иргэд тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл:

Дүүргийн хэмжээнд 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 3060 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 1702 (55.6%) нь гэмт хэргийн шинжтэй, 1358 (44.4%) нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл ирсэн байна.

ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, шалган шийдвэрлэсэн байдлаар, 2026 оны 1 дүгээр сард




Гэмт хэргийн шинжтэй 1702 гомдол мэдээллийн 1130 (66.4%) хэргийг шийдвэрлэснээс 364 (32.2%) нь хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн, 721 (63.8%) нь хэрэг нээхээс татгалзсан, 45 (4.0%) нь харъяаллын дагуу шилжүүлэн хэргийг шийдвэрлэсэн байна. Нийт шийдвэрлэсэн 1130 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг 5 хоногт 272 (24.1%) хэргийг, 6-19 хоногт 858 (75.9%) хэргийг

6-19 хоногт 30 (0.2%) тус тус шийдвэрлэн ажиллажээ.

Нийт шалган шийдвэрлэгдсэн зөрчлийн шинжтэй 1358 гомдол мэдээллийн 1194 (87.9%) хэргийг шийдвэрлэснээс 527 (44.1%) хэрэгт зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, 665 (55.7%) хэргийг нь зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 2 (0.2%) хэргийг нь харъяаллын дагуу шилжүүлсэн байна.

Зам тээврийн осол, зөрчил:

2026 оны 1 дүгээр сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт ослын шинжтэй 1835 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 70 (4.0%) дуудлагаар өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 12. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, дүүргээр, 2026 оны 1 дүгээр сард

Улаанбаатар хотод нийтдээ 1909 зам тээврийн осол бүртгэгдсний 643 (33.7%) нь Баянзүрх, 354 (18.5%) нь Хан-Уул, 259 (13.6%) нь Сонгинохайрхан, 376 (19.7%) нь Баянгол, 186 (9.7%) нь Сүхбаатар, 67 (3.5%) нь Чингэлтэй, 24 (1.3%) нь Налайх, Багахангай, Багануур дүүргүүдэд байна.

Бүртгэгдсэн ослыг дүүргийн хэмжээнд өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан авч 2.7 хувиар, эд материалын хохиролтой осол 5.5 хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 14. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2024 I	2025 I	2026 I	<u>2026 I</u> <u>2025 I</u>
	Тоо			хувь
Нийт	302	366	376	2.7
Эд материалын хохиролтой осол	289	345	364	5.5
Хүн гэмтсэн осол	13	21	12	-42.9

Нийт зам тээврийн осол 376 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 (2.7%) өссөн байна. Нийт бүртгэгдсэн зам тээврийн ослын 364 (96.8%) нь эд материалын хохиролтой осол, хүн гэмтсэн осол 12 (3.2%) буурсан байна.

2026 оны 1 дүгээр сарын байдлаар зам тээврийн ослын улмаас нийт 14 хүн бэртэж



үүнээс хүн нас барсан тохиолдол бүртгэгдээгүй байна. Зам тээврийн ослын улмаас бэртсэн иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирсон иргэн 8 (36.4%) буурсан эерэг өөрчлөлттэй байна.

ХҮСНЭГТ 15. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС БЭРТСЭН ИРГЭД, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2024 I	2025 I	2026 I	<u>2026 I</u> <u>2025 I</u>
	Тоо			хувь
Нийт хохирсон иргэд	15	22	14	-36.4
Хүн гэмтсэн	15	22	14	-36.4
Хүн нас барсан	-	-	-	-

ЗУРАГ 13.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, хэлбэрээр, тээврийн хэрэгслийн төрлөөр, дүнд эзлэх хувь, 2026 оны 1 дүгээр сард



Нийт гэмтсэн хүний 11 (78.6%) хувийг явган зочигч, 2 (14.3%) хувийг зорчигч, 1 (7.1%) жолооч эзэлж байна. Бүртгэгдсэн зам тээврийн ослын 356 (94.7%) нь мөргөлдсөн, 9 (2.4%) нь явган хүн дайрсан, 10 (2.7%) нь үл хөдлөх зүйл мөргөсөн, 1 (0.3%) нь онхолдсон байна. Зам тээврийн ослыг тээврийн хэрэгслийн төрлөөр нь 339 (90.2%) нь

суудлын, 23 (6.1%) нь ачааны, 9 (2.4%) нь автобус, 5 (1.3%) бусад төрөл эзэлж байна. Оны 1 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн зам тээврийн ослын 101 (29.0%) хэргийг даатгалд шилжүүлж, 210 (60.3%) хэрэгт акт тавьж, 37 (10.7%) хэргийн өргөдлийг хүлээн авсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

